



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ  
Д Ү Г Н Э Л Т

2021.02.23

№ 10

Улаанбаатар хот

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 2 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөл:

2. Зургийн шифр, зураг төслийн компани: ЗТ-15.01.21/02 “Зэндмэнэ тулга” ХХК

3. Барилга байгууламжийн зориулалт: Нийслэлийн Засаг даргын 2008 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 377 дугаартай шийдвэртэй, Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн ГБМЗХ2020/27-022 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавартай.

4. Барилга байгууламжийн давхар, талбай: 2 давхар, зоорьтой.

5. Галд тэсвэршилтийн зэрэг: төлөвлөсөн II

6. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф3.2:

7. Зургийн иж бүрдэл: 1 хэсэг

Хоёр. Барилга байгууламжийн зураг  
төслийн галын аюулгүй байдал

1. Гадна дулаалгын материалыг тэсвэрлэн шатдаг материал сонгож нормын дагуу гүйцэтгэх. /БД 23-103-10-ийн 8.5, 8.15/ Материалын шинжилгээнд өгч дүгнэлтийг хавсаргах.
2. Барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн хүчин чадлыг тооцоолж нормын дагуу төлөвлөх. /MNS5566:2020/. Галын дохиоллын хүлээн авагч станцыг хүн 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах.
3. Хот суурин төлөвлөлт барилгын зураг төсөл төлөвлөхдөө БНБД 30-01-04 барилга хоорондын гал тусгаарлах хамгаалалтын зай /заавал биелүүлэх 4-р хавсралт/ хэмжээг баримтлах.
4. Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21-02-02-ын 2-т Барилга, байгууламж, гал тусгаарлах заагийн гал тэсвэршилт 2.1, 2.4, 2.7, 2.8, 2.9-р заалтуудыг мөрдлөг болгох.

Гурав. Ерөнхий дүгнэлт

Дээрх шаардлагыг биелүүлснээр тус барилгын ажлын зураг нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа болно. /Ажлын зураг дээр зөвшилцөн засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай/

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Зөвшөөрсөн сар, өдөр	Зөвшөөрлийн тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2021.02.23.	Нүүр хуудас, БА 3-5, ХАС ЦБУ ХД	Барилгын ажлын зураг төслийг дүгнэлтийн дагуу хийж гүйцэтгэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ХЯНАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ДЭД ХУРАНДАА Н.ХИШИГБААТАР

